

МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДЫН ХУУЛЬ

1997 онд Төрийн бус байгууллагын тухай хууль анх
батлагдсан





МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД

Төрийн бус байгууллагын харилцаатай холбоотой асуудлыг дараах хууль, эрх зүйн актаар зохицуулж байна:

- Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль (2015)
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (2010);
- Засгийн газрын тухай хууль (1993);
- Хууль тогтоомжийн тухай хууль (2015);
- Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль (1994) ;
- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011);
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль(2015);
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай (1995);



Хууль эрх зүйн бусад акт:

- “Төр-хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого” УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоол;
- “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал –2030” УИХ-ын 2016 оны 19-р тогтоол;
- “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”, УИХ-ын 2012 оны 52-р тогтоол;
- “Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах тухай” Засгийн газрын 2008 оны 3 сарын 12-ны өдрийн 93-р тогтоол;
- “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай”, Засгийн газрын 2016 оны 3 сарын 21-ний өдрийн 165 дугаар тогтоол;
- “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол;
- “Төрийн бус байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн жагсаалт, Төрийн бус байгууллагын Санхүүгийн тайлан, түүний тодруулгыг бэлтгэх заавар, Төрийн бус байгууллагын Санхүүгийн тайлангийн маягт”, Сангийн сайдын 2005 оны 12 сарын 30-ны өдрийн 385 дугаар тушаал;
- “Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/84/А/59/А/130 дугаар хамтарсан тушаал;
- “Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам”, Уул уурхайн сайдын 2015 оны 4 сарын 29-ний өдрийн 81 дүгээр тушаал;



ТББ гэдэг нэр томъёо нь хууль хоорондын зөрчил, гажуудлыг бий болгосон ба түүний, өргөн ба явцуу утга бүхий хэрэглээ:

ТББ гэх ойлголтын талаар:

ТББ түүнийг хэрхэн ойлгох талаар дэлгэрэнгүй байдлаар 1997 оны Төрийн бус байгууллагын тухай хуульд л зохицуулсан ба “холбоо” гэсэн нэр томъёо одоог хүртэл тус хуульд байхгүй .

2002 онд шинэчлэн батлагдсан Иргэний хуулиар “ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэрүүдийг “холбоо, сан, хоршоо” гэж нэрлэсэн ... зохицуулсан. Улмаар Иргэний хуулийн 36.3 болон 36.5-д “Холбоо, сангийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно”,.

Үүний үр дагаварт хуульд нийцүүлэхийн тулд жнь: Хуульч эмэгтэйчүүдийн Холбоо гэж бүртгэлтэй байгууллага нь Хуульч эмэгтэйчүүдийн холбоо ТББ, Залуу удирдагч Сан байсан нь Залуу удирдагч сан ТББ гэх болсон.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУДАД

Мэргэжлийн холбоо, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн ялгаа, ижил төстэй тал ТББ-ын тухай хуулийн 3.1-д

“Энэ хууль нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс бусад төрийн бус байгууллагад хамаарна”

гэснээр ТББ-ыг өргөн хүрээнд ойлгож зохицуулсан гэж үзэхээр байна.

Цөөнгүй хуульд24

Мэргэжлийн холбоо гэх нэр томъёог хэрэглэсэнээс Нийтийн сонсголын тухай хууль (2015)-ийн 5.1.3-д

“мэргэжлийн холбоо” гэж нийтийн ашиг сонирхолд нийцсэн, мэргэжлээрээ эвлэлдэн нэгдсэн иргэдийн төрийн бус байгууллагыг”

ойлгох болохыг тодорхойлсон. Хэдийгээр гадаадын бусад улсын хууль тогтоомж болон тогтсон ойлголт дахь зарим нэг шинж болох :

- Иргэний хуулийн дагуу зохицуулагдах,
- мэргэжлийн эрх ашгийг хамгаалахаар эвлэлдэн нэгдсэн гэх мэт

шинжийг бүрэн дурдаагүй байх ч эдгээр нь ТББ-ын тухай хуулийн ТББ-ын тодорхойлолтоор нөхөгдөх боломжтой.



Үүнээс мэргэжлийн холбооны бусад Холбооноос ялгарах гол шинж нь мэргэжлээрээ эвлэлдэн нэгдсэн, иргэдээс бүрдсэн байх зэрэг болно.

Энэ тодорхойлолтод багтаж болохТББ-ыг дурдвал : - Монголын нотариатчдын танхим,

- МҮХАҮ-ийн дэргэд Арбитр,
- Мэргэшсэн нягтлан бодогчдын институт,
- Монголын агаарын нисэгчдийн холбоо,
- Монголын нислэгийн удирдагчдын холбоо,
- Монголын хохирол үнэлэгчдийн холбоо,
- Монгол Улсын өрөмдлөгийн холбоо зэргийг нэрлэж болно.

Ийнхүү Мэргэжлийн холбоог зөв тодорхойлохын гол ач холбогдол Төрөөс Мэргэжлийн холбоонд тухайн мэргэжилтэй холбоотой зарим чиг үүргийг шилжүүлэх эсхүл төрийн бодлого тодорхойлоход мэргэжлийн холбооны санал, зөвлөмж, дүгнэлтийг авах зэргээр Төрөөс харьцахад чухал ач холбогдолтой.



Манайд Мэргэжлийн холбоог хувийн эрх зүйн хуулийн этгээд буюу ТББ-ын тухай хуулиар зохицуулагдах Холбоо гэж үзэх үү эсхүл Нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж бие даасан хуулиар зохицуулах уу гэсэн онолын буюу зарчмын асуултанд хариулах хэрэгцээ байна.

ХБНГУ-ын зохиуцлалтаар

мэргэжилтнүүд өөрсдийн эрх ашгийг хамгаалах,

төрийн болон бусад байгууллагад лобби хийх зэрэг зорилго бүхий

Мэргэжлийн холбоодын **иргэний эрх зүйн** хуулийн этгээд буюу **Холбоо** гэж үзэж ТББ-ын тухай хуулиар зохицуулж

харин “тусгай зөвшөөрөл” шаардах өндөр хариуцлага бүхий, олон нийтэд үйлчлэх төрийн чиг үүрэг эдгээр мэргэжлээр дамжин хэрэгжих зэрэг шинжүүд байгаа тохиолдолд

Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн чадамжтэй **Мэргэжлийн холбоод** гэж үздэг ба Төрийн тухайн салбарын захиргааны төв байгууллагын ерөнхий хяналт дор үйл ажиллагаагаа бие даан, тусгайлсан хуулийн дагуу явуулдаг.



Нийгмийн бүхий л салбарт оролцож байгаагийн хувьд

- төрийн бүтэц хувьд улам данхайдаг,
- шат дамжлага ихсэхийн хэрээр
 - хүнд суртал,
 - авлига хээл хахууль нэмэгддэг

Харин төрийн иргэдэд хүргэж буй үйлчилгээ чанаржих,

- үр ашигтай,
- хөнгөн шуурхай,
- бүтээлч ажиллах,
- авлига, хүнд суртлаас ангид орчин бүрдэхэд
 - мэргэжилтний мэргэжлийн ур чадвар,
 - мэргэжлийн ёс зүй,
 - хариуцлагын тогтолцоо чухал нөлөөтэй.

Мэргэжлийн холбоодын үйл ажиллагааны эрх зүйн орчныг шат дараатайгаар бүрдүүлэхийн тулд

төр, төрийн бус байгууллагын харилцааны орчин,
мэргэжлийн холбоодын хөгжлийн хүрсэн түвшин - ийг харгалзаж үзэх хэрэгтэй болж байна.



Мэргэжлийн холбоо нь төрийн нэрийн өмнөөс чиг үүргийг шилжүүлэн авч гүйцэтгэхийн тулд:

1. тухайн салбарын бүх мэргэжилтнийг хамарсан,
2. албадан гишүүнчлэлтэй,
3. гишүүдээр хүлээн зөвшөөрөгдсөн зохицуулалтын эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх зүйн болоод бусад чиглэлийн
(санхүү, хүний нөөц, менежмент, засаглал, дотоод ардчилал, ёсзүй, мэдлэг, мэргэжлийн ур чадвар гэх мэт)
чадамжтай байгууллага байх ёстой

Харин дийлэнхдээ ашгийн төлөө хуулийн этгээдүүдээс бүрдсэн Холбоодыг бусад Холбоодоос ялгаж Эдийн засгийн сонирхол бүхий буюу Эдийн засгийн холбоод гэж ангилан, тэдгээрийн үйл ажиллагаанд зарим нэг хязгаарлалт, хориглолт хийх буюу өрсөлдөөнийг хязгаарласан шинжтэй үйл ажиллагаа явуулах, үгсэн тохирч зохиомол хомсдол, гачигдал үүсгэх байдлаар зах зээлийн үнийг өсгөх гэх мэт хэрэглэгч, олон нийтийн эрх ашигт харш үйлдэл, эс үйлдэхүйг хуулиар хориглох боломжтой.



ХБНГУ-ын холбоодын хуулийн бүтэц

Европын болон УЛС хоорондын мэргэжлийн нэгдсэн холбоод



Мэргэжлийн нэгдсэн холбоодын үндэсний зөвлөл



Мэргэжлийн нэгдсэн холбоод

Уялдаа бүхий салбар чиглэлээр
УЛСЫН хэмжээний үйл ажиллагаа

Мэргэжлийн тэргүүлэх холбоод

Уялдаа бүхий салбар чиглэлээр
Бүсийн хэмжээний үйл ажиллагаа

Мэргэжлийн дээвэр холбоод

Мэргэжлийн чиглэлээр
Бүсийн хэмжээний үйл ажиллагаа

Салбарын мэргэжлийн холбоод
Branchenverband

Мэргэжлийн байгуулагууд
Berufsverband

- Нэгдэл

- Хоршоо

- Бүлэг

- Клуб

хувь
хүмүүс



ҮНДЭСНИЙ АЖ ҮЙЛДВЭРИЙН ЗӨВЛӨЛ



**АНХААРАЛ
ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА**